



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024. оны 07 сарын 29 өдөр

Дугаар А/29

Мандалговь

Барилга, байгууламжийг ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 212 қдугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 1 дүгээр хавсралт, аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/406 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус аймгийн Говь-Угтаал сумын Морьт багийн төвийн барилгын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Буманбаатар	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	Э.Дүүрэнжаргал	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд	Ж.Уянга	(Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
	Х.Амартүвшин	(Зураг төсөл зохиогч “Стийл лайн” ХХК-ий архитектор)
	О.Энхбат	(Гүйцэтгэгч “Ривал констракшн” ХХК-ийн захирал)
	М.Амарзаяа	(Говь-Угтаал сумын Морьт багийн дарга)
	Т.Уранбайгаль	(Засаг даргын тамгын газрын Архивын тасгийн дарга)

2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс хууль, дүрмийн дагуу ажиллаж, барилгын норм ба дүрэм, зураг төсөлд нийцүүлэн дүгнэлт гарган, танилцуулахыг комисс (Б.Буманбаатар)-т даалгасугай.

ДАРГА

Э.ЧАГНААДОРЖ

4824010137